

КОМПАНИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

- 1. Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл** Хөнгөн Бетон ХК нь түрээс болон дэд бүтцээ ашиглуулах үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү тогтмол орлогоороо өр төлбөрөө барагдуулах нь бэлэн мөнгө хомсдолтой үед их нэмэртэй байлаа.
- 2. Удирдлагын талаарх мэдээлэл** Компанийн шинэ удирдлага нь дээрх хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас компанийг хэвийн авч явахад хүндрэлтэй байсан ба санхүүгийн тайлан балансыг гадны байгууллагаар хийлгэж ирсэн. Компани өөрийн гэсэн ажилчид байхгүй байна.
- 3. Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл** Компани 2019 онд 302,75 сая төгрөгийн орлого олсон. Авлагатай хувь хүн компаниуд тэдгээрийн шүүхийн шийдвэрийн өр төлбөрт тодорхой төлөлтүүд хийгдэн 8 хавтаст хэрэг байснаас 3 хавтаст хэргийг хаасан. 2 төлбөрийг 2020 онд хувиарт оруулан төлж эхлээд байна. Банкны болон бусад өр төлбөрүүд одоогоор оны эцсийн байдлаар хэвээр үлдэгдэлтэй байна.

4. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл

“Хөнгөн бетон” ХК-ийн нийт гаргасан хувьцааны тоо 179,373 ширхэг. 2019 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн байдлаар Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвөөс ирүүлсэн 5 ба түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигчдийн хувь эзэмшлийн судалгаагаар дараах байдлаар хувьцаа эзэмшиж байна.

| Д/д | Хувьцаа эзэмшигчдийн нэрс | Тоо ширхэг | Хувь |
|-----|---------------------------|----------------|--------------|
| 1 | Б.Наранзул | 57,399 | 32,0% |
| 2 | Н.Эрдэмбилэг | 53,842 | 30,0% |
| 3 | Б.Наранцацралт | 26,655 | 15,0% |
| 4 | Н.Эрдэмбаяр | 23,306 | 13,0% |
| 5 | “Минжит булган гол” ХХК | 14,918 | 8,3% |
| 6 | Т.Баярхүү | 1,034 | 0,6 |
| | | 177,154 | 98,9% |

5. Ногдол ашигийн талаарх мэдээлэл

- 1) “Хөнгөн бетон” ХК болон “Хас банк” ХХК-ийн хооронд 2012 оны 11-р сард байгуулагдсан “Хугацаат зээлийн гэрээ”-ний “Зээлдэгч нь аливаа ногдол ашиг зарлахгүй, олгохгүй” тухай “Хавсралт 3 В.1” дүгээр заалтыг үндэслэн ногдол ашиг олгохгүй байгаа.
- 2) “Хөнгөн бетон” ХК нь 2019 онд алдагдалтай ажилласан ба банкны өмнө хүлээсэн үүргийн дагуу ногдол ашиг хуваарилах боломжгүй.

Бусад шаардлагатай мэдээлэл

Гол түүхий эд нийлүүлэгч компанид олон жилийн өглөгийг хөрөнгө шилжүүлэхээр шүүхийн явцад эвлэрсэн. Одоогоор шилжүүлж чадаагүй байгаа бөгөөд газар нь банкны барьцаанд байгаа юм. Түрээсийн гэрээ нь их хэмжээний хэлцэлд тооцогдох ба жил бүр гэрээг дүгнэн явж байна. 2019 оноос компани бүхэлдээ зогсож зөвхөн түрээсийн үйл ажиллагаа эрхэлж байна.

ТУЗ-ИЙН ДАРГА  Б.НАРАНЗУЛ

